



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/114

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4, Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.2, 535 дугаар зүйлийн 535.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Уул овогт Лхамжавын Адъяадорж (ЕЙ45050918) нь нас барсан тул Шивээговь сумын 2-р баг, Олстын нуурын хойд талд байрлах 700м² өвөлжөө, хаваржааны зориулалттай газрын газар эзэмших эрхийг хуулийн дагуу өвлөх эрхтэй Шавь боржигин овогт Батмөнхийн Бямбасүрэн (ЕЙ53030307)-д өвөлжөө, хаваржааны зориулалтаар, өмнө нь авсан иргэний үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмших эрхийг өвлөн авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг иргэн /Б.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Батмөнхийн Бямбасүрэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Т.Өлзийбуд/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/20 тоот захирамжийн 4 дэх бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА